

## ХЯТАД - МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛТ

Монгол судлаач БААТАР

1999 оны аравдугаар сарын 16 өдөр бол БНХАУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосоны 50 жилийн ойн өдөр юм. Хятад, Монгол хоёр орон энэ тэмдэглэлт өдрийг өөр өөрийнхөөрөө өргөн дэлгэр тэмдэглэлээ. Хоёр орны уламжлалт найрамдлыг эргэн дурсаж, хоёр орны эдийн засаг, худалдааны салбарын солилцоо, хамтын ажиллагааны туршлагыг нэгтгэн дүгнэж, Хятад, Монголын харилцааны хөгжлийн хэтийн төлөвийг цэгнэн үзэх нь хоёр орны харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд тустай байх болно.

**Нэг.Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг эргэн харъя.**

Шинэ Хятад улс байгуулагдсанаас 60-аад оны эхэн хүртэл хоёр орны эдийн засаг, худалдааны харилцаа нэн сайн хөгжиж, хоёр талын удирдагчид олон удаа харилцан айлчилж олон гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж, хоёр улс улс төр, эдийн засаг, соёл, гадаад худалдаа гэх мэт олон талаар өргөнөөр хамтран ажиллаж байлаа. Хятад, Монголын харилцааны түүхийн энэхүү алтан үед хөрш хоёр орны ард түмэнд мартахын аргагүй хоёр үйл явдал бий. Нэг дэх нь гэвэл Хятадын Ерөнхий сайд Жоу Эньлай 1960 оны тавдугаар сарын 27-наас зургаадугаарын сарын 1-ний өдөр хүртэл Монгол Улсад айлчилж, тавдугаар сарын 31-ний өдөр хоёр тал “БНХАУ, БНМАУ-ын найрамдал, харилцан туслалцах гэрээ”-нд гарын үсэг зурсан ба мөн оны аравдугаар сарын 12-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон юм. Энэ тэмдэглэлт үйл явдал Хятад, Монголын харилцааны түүхэнд замын тэмдэг босгож хоёр орны харилцаанд чухал үүрэг гүйцэтгэв.

Хоёрдахь нь болбаас Монголын гол удирдагч Цэдэнбал 1962 оны арванхоёрдугаар сарын 25-27-ны өдөр Хятадад айлчилж, улмаар 1962 оны арванхоёрдугаар сарын 26-ны өдөр Бээжин хотноо “БНХАУ, БНМАУ-ын хилийн гэрээнд гарын үсэг зурсан нь 1963 оны гуравдугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон юм. Энэ үндсэн дээр хоёр тал найрсагаар хэлэлцэн тогтож, 1964 оны зургадугаар сард хятад Монголын хилийн протоколд гарын үсэг зурж, 4673 км урт Хятад Монголын хилийг амжилттай тогтоосон юм. Энэ бол Хятад, Монгол хоёр орны харилцааны түүхэнд ихээхэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон билээ.

60-аад оны дунд үеэс 80-аад оны эхэн хүртэл, Хятад Монголын харилцаа тогтвортой, холдсон байдалтай байв. 1989 онд хоёр орны

\*.Өвөр Монголын Зүүн хойт Ази судлалын  
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний  
ажилтан

харилцаа хэвийн болов. 1990 онд, Монгол улсын Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат анх удаа ЗХУ-д биш Хятадад айлчилсанаар Монгол Улс ЗХУ-ыг нэг талыг барьсан гадаад бодлогоо өөрчилж байгааг харуулж байна.

Мөн оны 7-р сард, хаагдаад 30 жил болсон Монгол улсаас Хөх хотод суугаа ерөнхий консулын газрыг албан ёсоор сэргээсэн нь хоёр орны харилцааны чухал гүүрийг дахин шинээр холбосон хэрэг юм. 1991 оны наймдугаар сард БНХАУ-ын дарга Янь Шанкунь Монгол улсад анх удаа айлчилсан нь хоёр орны харилцаа бодитойгоор хэвийн болсоны дараа Хятад, Монгол хөршийн найрсаг харилцааны чухал алхамыг цаашид ахиулсан юм. 1990-1998 онд, Хятадын удирдагч Янь Шанкунь, Ли Пэн, Цяо Ши болон Монголын удирдагч Очирбат, Бямбасүрэн, Багабанди нар харилцан амжилттай айлчлал хийж, 22 гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурав. Түүний дотор Хятадын Ерөнхий сайд Ли Пэн, Монголын Ерөнхий сайд П.Жасрай нар 1994 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо “БНХАУ, Монгол Улсын найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд” гарын үсэг зурсан нь хоёр орны харилцааны түүхэнд түүхэн үйл болж, хууль эрхийн үүднээс Хятад, Монголын найрамдал, хамтын ажиллагаа батжин бэхжиж, хоёр орны харилцааны ирээдүйд улс төрийн шинэ үндэс суурь тавьлаа. Энэ нь бас манай хоёр талын бүхий л үйл хэргийн үндсэн зарчим, хэм хэмжээ болов. Энэ нь БНХАУ ба Монгол улсын харилцааг хөгжлийн шинэ шатанд гаргаж, хоёр орны харилцааны түүхэнд бодолтой, гүн гүнзгий ач холбогдолтой үйл явдал болсоны билэг тэмдэг болж байна.

Хятад, Монголын харилцаа хэвийн болсоноос хойш, хоёр тал худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурж, улмаар хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээг өргөтгөж, хамтын ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгож, Хятад, Монголын орон нутгийн хил худалдааг ахиулж, улмаар хилийн районд эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны бүс байгуулах зэрэг нэлээд тодорхой тохиролцоонд хүрлээ. Ялангуяа хил худалдаа (1985), эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа сэргэсэнээс хойш (1988) 1998 оныг дуустал, Хятадын нийт 260 үйлдвэр худалдаа, аж ахуйн газар Монголд бүртгүүлсэний дотор 60 аж ахуйн газар албан ёсоор нээгдэн ажиллаж, хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 55 сая америк доллар болжээ. Хятад, Монголын худалдааны нийт хэмжээ мөн онд 250 сая ам.долларт хүрч, Монголын гадаад худалдааны нийт дүнгийн 15%-ийг эзлэж байгаа нь зөвхөн Оросын дараа хоёрдахь худалдааны түнш болж байгаа юм. Хятад улс Монголд 170 сая юаны тусламж үзүүлсэний дотор буцалтгүй тусламж 40 сая юань, бага хүүтэй зээл 130 сая юань юм. Үүнээс үзвэл, Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа нэгэнт сайн үндэс суурьтай болж, хөгжлийн чиг хандлагаа олжээ.



Хятад Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөгжил бол хоёр орны газар нутаг, соёлын давуу байдлаар тодорхойлогдоно.

Хятад, Монголын худалдааг бүс нутгаар нь хувааж үзвэл, гол нь Хятадын хил залгаа аймгуудад төвлөрчээ. 1998 оны Хятад, Монголын худалдааны нийт хэмжээнд, Өвөр Монгол ба Монгол улсын худалдаа 41%-ийг эзлэж байна. Монголын ард түмний зан заншил, хэв ёс Өвөр Монголтой бараг адил бөгөөд Монголын иргэд Хятадын бараа таваарыг, ялангуяа өдөр тутмын бараа бүтээгдэхүүнийг хэрэглэж дасчээ. Өвөр Монголчууд Монголын ард иргэдийн хэрэглээний дадал, хэрэглээний эрэлт хэрэгцээг ч сайн мэддэг юм. Энэ бол Өвөр Монгол ба Монгол Улсын хилийн худалдаа тасралтгүй өсөн нэмэгдэхийн үндсэн шалтгаан болох юм. Сүүлийн хэдэн жилд, Өвөр Монгол, Монгол Улсын хил худалдаа 50-80 сая америк долларын түвшингээ хадгалан барьсаар байна.

Сүүлийн 10 жилд, Хятад Монголын эдийн засаг худалдааны харилцаа тус хоёр орны эдийн засгийн шилжилтийн нөхцөлд явагдсан юм. Иймээс хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх зам, арга хэлбэрийг эрж хайх явцдаа байлаа гэж болно. Өнөөгийн байдлыг задлан шинжилбэл, хоёр орны харилцаанд нөлөөлж байсан хүчин зүйлүүд байлаа. Үүнд:

1.Хятад, Монгол хоёр орны шилжилтийн үеийн улс төрийн бодлогын зохицуулалт нь 2 талын харилцаанд зохицуулагч нөлөөтэй байв.

2.Хоёр талын гадаад худалдааны аж ахуйн нэгж, бараа бүтээгдэхүүний нэр хүнд харьцангуй доогуур байна.

3.Улс орнуудын өрсөлдөөн нэмэгдэх нь хоёр талын худалдаанд үлэмжхэн нөлөөлж байна.

4.Оросын хүчинд түшиглэж байсан Монгол улс богино хугацаанд өөрчлөгдөхөд хэцүү байв.

Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хөгжлийн хэтийн төлөвдийг авч үзвэл дараахи ашигтай нөхцөл байна. Үүнд:

1.Хоёр орны Засгийн газар хоёр талын худалдааны хамтын ажиллагааг чухалчилан анхаарч байна.

2.Хоёр талын хөрөнгө оруулалт, худалдаа хийх орчин байнга сайжирч байна.

3.Хоёр орны үйлдвэрлэлийн бүтэц харьцангуй хүчтэй, харилцан нөхөх чанартай юм.

4.Хоёр орны эдийн засаг, худалдааны харилцаанд хамтын ажиллагааны хэлбэрээс зах зээлийн эдийн засгийн шилжилтэнд, худалдааны хэлбэрээс олон талт шилжилтэнд, тооцооны хэлбэрээс бэлэн мөнгөний худалдаанд, хил худалдаанаас гүний худалдаанд, бүтээгдэхүүний солилцооноос эдийн засаг- технологийн хамтын ажиллагаанд шилжих гэх мэт ашигтай хувирал өөрчлөлт гарч байна.

## **Хоёр. Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, харилцааны ирээдүй**

Монголын Улсын Их Хурлын 1999 оны хаврын чуулганаар баталсан, XXI зууны эхэн үед улсын эдийн засгийг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөнд, Зүүн бүс нутгийн хөгжлийг урагшлуулах, бусад бүс нутгийг хөгжүүлэх стратеги, мөн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах асуудлыг тусгалаа. Энэ нь Хятад, Монгол орны хамтын ажиллагаанд улам их боломж олгож, хоёр талын давуу тал, харилцан нөхөх чанарыг цаашид илүү хөгжүүлэхэд тустай боллоо. Хятад Улсын оролцож байгаа Монголын Дорноговь аймгийн чулуун тосыг нээж ашиглах ажлын явц 1999 онд нэлээд ахиц оллоо. Хятад Улс, Монголын Дорнод бүс нутгийн хамтын ажиллагаа нь хоёр орны эдийн засаг, худалдааны харилцааг цаашид хөгжүүлэх гарааны цээг, улмаар Түмэн голын бүс нутгийн хамтын ажиллагаа зэрэг Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд улам их хувь нэмэр болох юм.

Хоёр талын хамтын ажиллагааны хөгжлийн ерөнхий хандлага нь хамрах хүрээ, хэмжээ далайцаараа цаашид нэн өргөжинө. Гэхдээ Монголын зах зээлийн багтаамж бага, экспортын нөөц баялаг хязгаартай, төлбөрийн чадвар хангалтгүй тул ойрын хугацаанд хоёр талын худалдааны хэмжээ өсөхөд хэцүү бөгөөд хоёр тал өөр өөрийн экспортын барааны давуу талаа ашиглаж, худалдаагаа тодорхой хэмжээнд хүргэж чадна. Улмаар хоёр талын эдийн засаг-техникийн хамтын ажиллагаа цаашид ч өргөжих нь дамжиггүй.

1. Монголд аж үйлдвэрийн бүрэн хэлбэршсэн үйлдвэрлэлийн систем байхгүй, үйлдвэрлэлийн ихэнхи бүтээгдэхүүн импортын байна. Хятадад нэгэнт аж үйлдвэрлэлийн харьцангуй бүрэн систем тогтож, хөнгөн болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл түргэн хурдацтай хөгжиж, барааны бүтэц нэр төрөл нэн олон янз байна. Иймээс ч ойрын жилүүдэд Хятад, Монголын худалдааны бүтэц мөн л Монгол Улсын анхан шатны бүтээгдэхүүнийг Хятадын аж үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүнээр солилцох онцлог хэвээр байх болно. Монголын аж үйлдвэрт бүтцийн зохицуулалт хийж ахиц дэвшил гарсаны дараа, экспортын барааны бүтэц аажмаар өөрчлөгдөж, боловсруулаагүй мал аж ахуйн бүтээгдэхүүн, модон материал зарим төрлийн уул уурхайн түүхий эд аажмаар багасч, анхан шатны болон дахин, бүрэн боловсруулсан аж үйлдвэрийн барааны төрөл, тоо хэмжээ аажмаар өсөх болно.

2. Одоо Монгол Улсад өндөр үр ашигтай, хэрэглэхэд тохиромжтой, үйлдвэрлэлийн тэргүүний технологи маш хэрэгцээтэй байна. Энэ хэрэгцээг хангаж чадвал үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвар нь нэмэгдэнэ. Хятадын нөхцөл бололцоотой үйлдвэр, аж ахуйн газрууд, Монголтой хамтран эрхлэх, хамтран үйлдвэрлэх, хөдөлмөр, үйлчилгээг хамтран хийх гэх мэт хэлбэрээр



Монголд хөрөнгө оруулж үйлдвэр байгуулж болно. Мөн техник нийлүүлж, худалдаж, хувьцаагаар оруулах зэрэг хэлбэрээр Монголд шинэ техник экспортлох ажил зохион байгуулж болох юм. Олон орон өрсөлдөж буй нөхцөлд, хоёр талын эдийн засаг-техникийн хамтын ажиллагаа нь хоёр талын олон зүйлт хамтын дагнасан хамтын ажиллагаа явуулах хэлбэрийг ашиглаж болно.

3. Монгол Улс байгаль орчиноо хамгаалахын зэрэгцээ байгалийн баялагаа нээж ашиглах чиглэл баримталж байна. Ойрын жилүүдэд хамтран ашиглаж болох нөөц баялаг гэвэл хагалсан газар, барилгын материал, мал аж ахуйн түүхий, аялал жуулчлал хийгээд зэс, алт, нефть, төмөр зэрэг уул уурхайн баялаг юм. Цаашдаа өнгөт төмөрлөг, нутаг бэлчээр, ой мод хийгээд бусад ашигт малтмалын нөөцөө нээж ашиглавал ихээхэн ахиц олно.

4. Монголын эдийн засаг сэргэж, өндийж байна. Ийм үед зах зээл бий болгох, эрчим хүч, тээвэр, мэдээлэл зэрэг суурь бүтээн байгуулалтын асуудлыг давын өмнө шийдвэрлэх хэрэгтэй. Үүний тулд зах зээлд барилга байгууламж аяндаа шаардагдана. Барилгын ажлыг Хятадын тал хариуцан хийх хэрэгцээ аажмаар өсөх хандлагатай байна. Ойрын жилүүдэд бага, дунд хэмжээний барилга барихыг голлож, цаашдаа нэлээд төвөгтэй том хэмжээний барилгын төслийг хамтран хэрэгжүүлж болно.

#### **Гурав. Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны тухай хэдэн санал**

1. Эдийн засгийн хөгжил, улс төрийн тогтвортой байдлыг харахад, холбогдох эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд, Хятадын гадаад эдийн засаг, худалдааны ерөнхий зорилт, гадаадтай нээлттэй байх бодлогод чухал байр эзлэх ёстой бөгөөд, хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, Монголын зах зээлд давуу байр эзэлж, Америк, Япон зэрэг өрнөдийн улсуудыг сөрөн зогсох хүч чадлаа нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

2. Хятад улс нэг хүнд ногдох байгалийн баялаг хомс Монгол улс байгалийн их баялагтайгаараа онцлог юм. Хоёр орны эдийн засаг тодорхой харилцан нөхөх чанартай. Хятадын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг харахад, Монголын ашигт малтмалыг нээж ашиглах талаар хөрөнгө оруулалтын стратеги боловсруулж, Монголын одоогийн гадаад эдийн засаг-техникийн хамтын ажиллагааны хөгжлийг тус улсын эдийн засгийн хэрэгцээтэй уялдуулан, Хятадын ажиллах хүч, техник зэрэг давуу талыг ашиглан, хөдөлмөр, үйлчилгээ, тээвэр болон техникийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, олон талт хамтын ажиллагааны хэлбэрээр ашигт малтмалыг нээж ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй.

3. Хоёр орны одоогийн худалдааны хэмжээг аажмаар нэмэгдүүлж, хоёр тал тохиролцсоны үндсэн дээр, худалдаанд шаардагдаж буй тооцооны

систем бий болгож, боловсронгуй болгох нь олон суваг, олон давхарга, олон хэлбэрийн худалдааны хамтын ажиллагааны сайн үндэс суурь тавьж чадах юм.

4."Чанарыг эрхэмлэх" стратегийг тууштай хэрэгжүүлж, чанартай сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, нэр хүндтэй, бараа борлуулах найдвартай суваг бий болгож, аль болох ихээр зах зээл олох хэрэгтэй. Монголын зах зээлийн байдлыг салбар төрлөөр нь судалсны үндсэн дээр, зах зээлийн хэрэгцээг үндэслэж, зохих цагт нь бараагаар хангаж, Хятадын экспортын бараа, бараа ба Монголын зах зээлийн эрхлэлт, хүлээн авах чадлыг хязгаартайгаар дээшлүүлэх хэрэгтэй юм.

5.Хятад, Монголын эдийн засаг, худалдааны харилцаа сэргэсэнээс хойш, хэлхээ харилцаа жилээс жилд нэмэгдэж байв. Гэвч улс орны бодит байдал, улс төр, эдийн засгийн систем зэрэг нөхцөл байдлыг гүйцэд ойлгоогүйгээс эдийн засаг, худалдааны харилцаанд саад учирсаар байна. Иймээс хоёр орны албаны болон тусгай мэргэжлийн хүмүүс харилцан айлчлахаас мэргэжлийн хүмүүс харилцан айлчлахаас гадна Хятад, Монголын найрамдлын нийгэмлэг зэрэг олон нийтийн байгууллага хийгээд бусад аливаа ашигтай сувгийг ашиглаж, хоёр орны харилцааны өнгөрсөн, одоо, ирээдүйг өргөнөөр сурталчилж, Монголын талаас Хятадад эргэлзэж, болгоомжилсон байдлыг арилгах хэрэгтэй юм.Мөн чухал хэрэгтэй олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, мэдээлэл солилцож, харилцаа холбоо тогтоох, Хятад, Монгол хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хэтийн төлөвийн талаар урьдчилан, боломжтой судалгаа хийж байхыг зохих байгууллагууд анхаарах хэрэгтэй буй за.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав